



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: soo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

.....	3
.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 16	
АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СҮХБААТАР АЙМГИЙН ЖААХАН
ШАРГА ТЕАТРЫН ДАРГА Г.БАЯРЦОГТ
ТАНАА

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 105
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 94,710.0 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Үндсэн цалин 111,161.4 мянган төгрөг буюу 14 хувиар өссөн боловч цалинтай холбоотой бусад зардал 119,327.5 мянган төгрөгөөр буурч нийт дүнгээрээ 0.8 хувь 8,166.1 мянган төгрөгий цалин ба түүнтэй холбоотой зардал буурсан байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд Сүхбаатар аймаг байгуулагдсаны 80-н жилийн ойн арга хэмжээнд зориулсан уран бүтээлийн санхүүжилт, шинэ кино хийхэд зарцуулагдах зардлын ажил гүйлгээнээс өөрөөр санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 5 хөтөлбөр, зорилтын хүрээнд 26 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 90.9 хувьтай биелсэн гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	233,456,305.73	292,520,749.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,013,594.68
31211	Төрийн сангийн харилцах	-	2,013,594.68
33	АВЛАГА	5,549,240.00	-
3351	Байгууллагаас авах авлага	5,549,240.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	227,907,065.73	284,957,914.73
351	Түүхий эд материал	69,976,235.40	109,536,235.40
35110	Тусгай зориулалттай материал	69,976,235.40	109,536,235.40
354	Хангамжийн материал	157,930,830.33	175,421,679.33
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	307,997.00
35420	Аж ахуйн материал	35,532,881.00	40,202,692.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	48,000.00
35470	Бусад хангамжийн материал	122,197,949.33	134,862,990.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,610,994,598.44	2,511,569,322.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,610,994,598.44	2,511,569,322.29
392	Биет хөрөнгө	2,551,090,598.44	2,450,058,238.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,554,787,648.00	2,554,787,648.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(180,146,733.76)	(245,215,998.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,300,000.00	73,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,311,111.14)	(32,977,777.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	289,643,292.14	296,463,292.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	(184,211,624.92)	(211,171,001.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,740,429.60	118,432,229.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(94,711,301.48)	(103,560,152.32)
393	Биет бус хөрөнгө	59,904,000.00	61,511,083.31
39301	Програм хангамж	750,000.00	2,745,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(1,137,916.69)
39303	Бусад биет бус хөрөнгө	59,904,000.00	59,904,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,844,450,904.17	2,798,540,831.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,290,259.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,290,259.00	-
413	Өглөг	2,290,259.00	-
4136	Бусад өглөг	2,290,259.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	434,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,856,259.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,842,160,645.17	2,804,090,071.70
51	Засгийн газрын хувь оролцоо	2,842,160,645.17	2,804,090,071.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	906,369,876.63	906,369,876.63
512	Хуримтлагдсан үр дүн	(80,736,013.49)	(118,806,586.96)
51210	Өмнөх үеийн үр дүн	(80,736,013.49)	(78,445,754.49)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(45,910,072.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,016,526,782.03	2,016,526,782.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,844,450,904.17	2,798,540,831.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,308,506,750.00	1,561,571,058.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	27,945,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	27,945,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	27,945,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,945,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,308,506,750.00	1,533,625,658.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,141,213,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	10,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	1,131,213,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,221,650.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,221,650.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,301,285,100.00	392,411,858.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,301,285,100.00	392,411,858.83
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,507,221,849.86	1,601,931,891.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,507,221,849.86	1,601,931,891.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,477,714,804.30	1,532,612,652.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	780,585,472.85	891,746,842.44
210101	Үндсэн цалин	780,585,472.85	891,746,842.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,809,930.63	111,482,446.71
210201	Тэтгэврийн даатгал	70,777,815.57	76,932,412.53
210202	Тэтгэмжийн даатгал	7,886,623.35	9,050,872.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,289,138.23	7,149,977.57
210204	Ажилгүйдлийн даатгал	1,441,486.90	1,660,518.16
210205	Эрүүл мэндийн даатгал	144,414,866.58	16,688,666.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,411,357.50	300,516,461.00
210301	Гэрэл, цахилгаан	5,884,119.00	7,693,651.00
210302	Түлш, халаалт	286,527,238.50	285,533,710.00
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	7,289,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,918,099.93	22,339,833.00
210401	Бичиг хэрэг	2,498,950.00	2,363,699.00

210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	12,632,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	951,748.00	1,450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,127,900.00	5,893,294.00
210408	Бараа материал акталсны зардал	16,839,501.93	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,343,340.00	12,681,295.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,344,900.00	-
210604	Урсгал засвар	24,998,440.00	12,681,295.00
2107	Томилолт, зочны зардал	1,768,000.00	6,154,800.00
210702	Дотоод албан томилолт	1,768,000.00	6,154,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,533,376.00	67,796,898.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,538,031.00	67,796,898.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	137,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,438,421.00	-
210807	Газрын төлбөр	359,424.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,345,227.39	119,894,076.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,962,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,345,227.39	110,932,076.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,507,045.56	69,319,239.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	69,311,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	66,943,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	2,368,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,539.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,539.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,407,045.56	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,407,045.56	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(198,715,099.86)	(40,360,832.47)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(198,715,099.86)	(40,360,832.47)
225002	Найдваргүй авлагын алдагдал		5,549,240.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		(5,549,240.00)
V	НИЙТ ҮР ДҮН	(198,715,099.86)	(45,910,072.47)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,308,506,750.00	1,561,571,058.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	27,945,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	27,945,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	27,945,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,945,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,308,506,750.00	1,533,625,658.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,141,213,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	10,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	1,131,213,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,221,650.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,221,650.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,301,285,100.00	392,411,858.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,301,285,100.00	392,411,858.83
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,295,951,550.00	1,548,050,664.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,295,951,550.00	1,548,050,664.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,266,444,504.34	1,478,731,425.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	780,544,596.21	893,915,843.14
210101	Үндсэн цалин	780,544,596.21	824,492,742.59
210102	Нэмэгдэл	-	41,571,269.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,494,000.00
210104	Урамшуулал	-	14,357,830.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,809,930.63	111,482,446.01
210201	Тэтгэврийн даатгал	70,777,815.57	76,932,412.53
210202	Тэтгэмжийн даатгал	7,886,623.35	9,050,872.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,289,138.23	7,149,977.57
210204	Ажилгүйдлийн даатгал	1,441,486.90	1,660,518.16
210205	Эрүүл мэндийн даатгал	14,414,866.58	16,688,665.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,411,357.50	300,516,461.00
210301	Гэрэл, цахилгаан	5,884,119.00	7,693,651.00
210302	Түлш, халаалт	286,527,238.50	285,533,710.00
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	7,289,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,878,598.00	21,732,036.00
210401	Бичиг хэрэг	2,498,950.00	2,491,696.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	12,632,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	751,748.00	1,450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,127,900.00	5,157,500.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	999,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	999,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,892,340.00	13,786,600.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,893,900.00	2,300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	833,000.00
210604	Урсгал засвар	24,998,440.00	10,653,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,768,000.00	6,154,800.00
210702	Дотоод албан томилолт	1,768,000.00	6,154,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,139,682.00	119,363,639.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,183,316.00	119,363,639.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	137,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,399,442.00	-
210807	Газрын төлбөр	359,424.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,780,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,780,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,507,045.66	69,319,239.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	69,311,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	66,943,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	2,368,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,539.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,539.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,407,045.66	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,407,045.66	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,555,200.00	13,520,394.68
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	11,506,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	11,506,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	11,506,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	7,936,800.00
223001	Бусад хөрөнгө	-	3,570,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(11,506,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,555,200.00	2,013,594.68
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,013,594.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(80,736,013.49)	2,842,160,645.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(80,736,013.49)	2,842,160,645.17
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(80,736,013.49)	2,842,160,645.17
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(80,736,013.49)	2,842,160,645.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,290,259.00	2,290,259.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(78,445,754.49)	2,844,450,904.17
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(45,910,072.47)	(45,910,072.47)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(124,355,826.96)	2,798,540,831.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,509,972,700.00	1,559,557,464.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,972,700.00	1,559,557,464.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,442,261,000.00	1,490,238,225.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	894,456,700.00	893,915,843.14
210101	Үндсэн цалин	737,903,600.00	824,492,742.59
210102	Нэмэгдэл	103,800,000.00	41,571,269.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,494,000.00
210104	Урамшуулал	52,753,100.00	14,357,830.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,806,900.00	111,482,446.01
210201	Тэтгэврийн даатгал	76,028,700.00	76,932,412.53
210202	Тэтгэмжийн даатгал	8,944,700.00	9,050,872.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,155,500.00	7,149,977.57
210204	Ажилгүйдлийн даатгал	1,788,900.00	1,660,518.16
210205	Эрүүл мэндийн даатгал	17,889,100.00	16,688,665.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,574,200.00	300,516,461.00
210301	Гэрэл, цахилгаан	8,350,000.00	7,693,651.00
210302	Түлш, халаалт	286,324,200.00	285,533,710.00
210303	Цэвэр, бохир ус	5,900,000.00	7,289,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,607,200.00	21,732,036.00
210401	Бичиг хэрэг	2,499,600.00	2,491,696.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	12,632,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,000.00	1,450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,157,600.00	5,157,500.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	999,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	999,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,699,600.00	18,928,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,666,400.00	5,866,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	833,200.00	833,000.00
210604	Урсгал засвар	6,200,000.00	12,228,600.00

2107	Томилолт, зочны зардал	2,163,900.00	6,154,800.00
210702	Дотоод албан томилолт	2,163,900.00	6,154,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	106,952,500.00	123,858,639.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,952,500.00	121,358,639.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,711,700.00	69,311,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,711,700.00	69,311,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	768,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,943,700.00	66,943,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,368,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,539.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,539.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,561,571,058.83
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,141,213,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	1,131,213,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	392,411,858.83
132001	Орон нутгийн төсвөөс	-	392,411,858.83
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	27,945,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,945,400.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,013,594.68

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	10,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр нь жүжиг, хөгжим, бусад урлагийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг төрийн байгууллага. Дорнод Монголын ард түмний уламжлалт ёс зан заншлын давтагдашгүй онцлогийг орчин үеийн дэвшилтэт ололтоор баяжуулан хөгжүүлсэн, Монголын соёл урлагийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц уран бүтээлээр үзэгчдэд үйлчлэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаахан шарга театр 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,070.6 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,013.6	2,013.6
Бараа материал	227,907.1	284,957.9	57,050.8
Үндсэн хөрөнгө	2,610,994.6	2,511,569.3	(99,425.3)
Нийт хөрөнгө	2,844,450.9	2,798,540.8	(45,910.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,844,450.9	2,798,540.8	(45,910.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,844,450.9	2,798,540.8	(45,910.1)

Тайлант хугацаанд харилцах дансны үлдэгдэл 2,013.6 мянган төгрөг үлдсэн нь эргэлтийн хөрөнгийн дүнг өсөлтөнд нөлөөлсөн байна.

Бараа материал 284,957.9 мянган төгрөг үлдсэн ба 57,050.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Шинэ уран бүтээл /Ялгуулсан хутагтын дууль кино, бүжгийн хөгжим гэх мэт/ гаргахад зориулан гаргасан хөрөнгийн дүнгээр бараа материалын дүн нэмэгдэх шалтгаан болжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,511,569.3 мянган төгрөг болж, 99,425.3 мянган төгрөгөөр буурсан бөгөөд 11,506.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан ба 110,932.1 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардал гарсан нөлөө байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 253,064.3 мянган төгрөг буюу 19 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь тоглолтын орлого өссөнөөс гадна Сүхбаатар аймаг байгуулагдсаны 80-н жилийн ойн арга хэмжээ ба бусад уран бүтээлийн санхүүжилт, тэтгэвэрт гарсан ажилтанд олгосон тэтгэмжийг олгох зарцуулалтууд нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 94,710.0 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь тэтгэвэрт гарсан ажилтанд олгосон 66,943.7 мянган төгрөгийн тэтгэмж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 44,263.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Цалин, нийгмийн даатгалын зардал 8,166.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 10,578.3 мянган төгрөг, 13,662.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,010,436.2 мянган, нийт зарлагыг 2,010,436.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 500,463.5 мянган төгрөгөөр бууруулж, 1,509,972.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 зорилт, 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,509,972.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,131,213.8 мянган

төгрөгийг улсын тусгай зориулалтын төсвөөс санхүүжүүлж, орон нутгийн төсвөөс 375,398.3 мянган төгрөг нийт 1,506,612.1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж төлөвлөгөөний биелэлт 99.8 хувь байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа уран бүтээлийн зардал	1,509,972.7	1,506,612.1	3,360.6	99.8%
НИЙТ		1,509,972.7	1,506,612.1	3,360.6	99.8%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗДНХ, түүнтэй адилтгах хөрөнгөөс 10,000.0 мянган төгрөг, Соёлын яамнаас хуваарилсан 15,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 27,945.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр “Тэ Арт” ХХК-д шилжүүлэн шинэ уран бүтээлийн гэрээт ажлыг санхүүжүүлэхэд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн МНБ, ТМЗ, аудитор Б.Бүзмаа, аудиторын туслах Л.Золбоо нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор С.Энхтөр Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 130/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 22,608.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 15,825.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 765.3-44,263.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: Тээвэр, шатахууны зардал 5,132.8 сая төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 765.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 44,263.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал нь Сүхбаатар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан болон шинэ кино, бүжгэн жүжиг зэргийг санхүүжүүлэхтэй холбоотойгоор зардал нэмэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрт нь 2022 онд нийт мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг хугацаанд нь ил тод байршуулжээ. Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш төгрөгийн зарцуулалт нь шинэ кино хийх болон уран бүтээлтэй холбоотой зардал байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрт завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 100% бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,163.3	2	1,163.3	100%
Албан шаардлага	1	5,601.3	1	5,601.3	100%
Зөвлөмж	1	1,428,376.0	1	1,428,376.0	100%
Нийт дүн	4	1,435,140.6	4	1,435,140.6	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,156.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 345.4 мянган төгрөгийн алдааг залруулж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 1 зөвлөмжийг хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хуримтлагдсан элэгдлийн зардлаар анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлгээ хийж ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоогоогүй 101 нэр төрлийн хөрөнгө бүртгэлд тусгагдсан.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар мөрдөж байгууллагын НБББББ стандартын дагуу бүртгэлд тусгах.

Илрүүлэлт: 46,811.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулалгүй хийсэн.

Өгсөн зөвлөмж: . НББ-ийн тухай хуулийн 5,13-р зүйл заалт, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.1-р зүйл заалтыг хэргэжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
					Тоо	Дүн	Тоо	Дүн		
101 ширхэг эд хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссаныг стандартын дагуу бүртгэл хөтлөөгүй	1		1				1		1	
ХХОАТ-ын тайланд 1 хүний цалингийн зардал дутуу тайлагнасан	1	118.2	1	118.2	1	118.2				
Худалдан авалтын зардлыг / https://ebarimt.mn/ цахим төлбөрийн баримтын систем/ цахим баримтаар нотлоогүй.	1	46,811.6	1	46,811.6			1	46,811.6	1	46,811.6
Цалингаас 3 хүний нийгмийн даатгалыг илүү суутгаж цалин дутуу олгосон	1	227.2	1	227.2	1	227.2				
Дүн	4	47,156.9	4	47,156.9	4	345.4	2	46,811.6	2	46,811.6

